

# ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

10.19 - 10.23



## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

**АНУ:** Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд холимог үзүүлэлттэй байлаа. Технологийн компаниудыг илүүтэйгээр агуулдаг Nasdaq индекс Apple компанийн хувьцааны үнийн уналттай холбоотой бууралттай байсан бол S&P MidCap 400 болон small-cap Russel 2000 индексүүд бага зэрэг өсөлттэй байлаа. S&P 500 индексийн сагсанд багтах технологийн салбар хамгийн их бууралттай байсан бол Facebook компани болон Alphabet компанийн хувьцааны ханш өссөнтэй холбоотой харилцаа холбооны салбар хамгийн их өсөлтийг үзүүллээ.

АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп энэ амралтын өдрүүдээр Ардчилсан намаас дэвшүүлсэн эдийн засгийг дэмжих хөтөлбөрийг 2.2 их наяд ам.доллороос илүү дүнтэй байсан ч дэмжинэ гэж мэдэгдсэнтэй холбоотой фьючерсийн үнүүд өссөн ч Сенатад олохын суудалтай Бүгд найрамдах нам тус хөтөлбөрийг дэмжихгүй байгаатай холбоотой хөрөнгийн зах зээлийн индексүүд Даваа гарагт бууралттай байжээ. Гэсэн хэдий ч АНУ-ын Сангийн нарийн бичгийн дарга ноён Стивен Мнучин болон Танхимын дарга хатагтай Нэнси Пелоси нар зөвшилцөлд хүрч байгаа ба Пүрэв гарагт Танхимын дарга хатагтай Нэнси Пелоси эдийн засгийн хөтөлбөрийг батлахад "их ойр байгаа" гэж мэдэгдсэнтэй холбоотой индексүүд бага хэмжээгээр өссөн байна.

**Европ:** Коронавирусийн халдварын тоог хязгаарлах зорилготой авч буй арга хэмжээнүүд эдийн засгийн сэргэлтэд сөргөөр нөлөөлж байгаатай холбоотой Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт бууралттай хаагдлаа. STOXX Europe 600 индекс 1.36%-аар, DAX индекс 2.04%-аар, CAC 40 индекс 0.53%-аар, FTSE MIB индекс 0.54%-аартус тус буурсан байна. Харин Их Британи улс Европын холбоотноос гарсны дараагаар хэрхэн худалдаа хийхтэй холбоотой уулзалтууд дахин явагдаж эхэлснээр фунтийн ханш өсөж FTSE 100 индекс 1.00%-аар буурсан байна. Их Британид бүртгэлтэй ихэнх компаниуд олон улсад үйл ажиллагаа явуулан гадаад валютаар орлого олдог тул фунтийн ханш өсөхөд хувьцааны ханшууд буурдаг байна.

**Япон:** Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт өсөлттэй хаагдлаа. Nikkei 225 индекс 106 нэгжээр буюу 0.5%-аар өсөж 23,516.59 нэгж хүрсэн нь энэ оны эхэн үетэй харьцуулахад 0.6%-аар буурсан үзүүлэлт болсон байна. Харин Япон улсын хөрөнгийн зах зээлийг бүхэлд нь илтгэдэг large-cap TOPIX болон TOPIX small индексүүд холимог үзүүлэлттэй байлаа.

Японы Төв Банкны бодлогын хороо 10-р сарын 28-29-ний өдрүүдэд хуралдах бөгөөд 2021 оны 3-р сарын 31-нд дуусгавар болох санхүүгийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) өсөлт болон инфляцын төсөөллөө бууруулах төлөвтэй байна.

**БНХАУ:** Энэ долоо хоногт БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд бууралттай хаагдсан байна. CSI 300 индекс болон Shanghai Composite индексүүд 1.5% болон 1.8%-аар тус тус буурсан ба БНХАУ-ын 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж мөн буурсан байна. Хятадын Ардын Банкны Ерөнхийлөгч ноён И Ган ойрын саруудад эдийн засгийн өсөлт эрчимжиж БНХАУ-ын өрийн гол харьцаа сайжрах магадлалтай байгаа ба Төв банк БНХАУ-ын эдийн засгийг дэмжихэд тэнцвэртэй хандлагыг баримтална гэж мэдэгджээ.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	17,396.36	-0.60% ▼
Dow Jones	АНУ	28,335.57	-0.95% ▼
S&P 500	АНУ	3,465.39	-0.53% ▼
Nasdaq	АНУ	11,548.28	-1.06% ▼
S&P/TSX	Канад	16,304.08	-0.82% ▼
FTSE 100	Их Британи	5,860.28	-1.00% ▼
S&P/ASX 200	Австрали	6,167.00	-0.16% ▼
Nikkei 225	Япон	23,516.59	0.45% ▲
Hang Seng	Хонг Конг	24,918.78	2.18% ▲

Бонд	Валют	Купон	Өгөөж
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	4.39%
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	3.92%
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	3.73%
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	2.05%
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	1.08%
DBM' 2023	USD	7.250%	5.14%
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	11.61%
Mongol 2026 (Номад)	USD	5.125%	4.45%

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.151	0.04 ▲
Libor 3M	0.218	-0.03 ▼
Libor 6M	0.258	0.05 ▲
Libor 1YR	0.335	-0.04 ▼
US 2YR Bond	0.149	-0.02 ▼
US 3YR Bond	0.188	-0.05 ▼
US 5YR Bond	0.330	-0.02 ▼
US 10YR Bond	0.759	-0.02 ▼

Валютын ханш	2020.10.23	Өөрчлөлт
USD	2,852.33	-0.04% ▼
CNY	427.65	0.46% ▲
EUR	3,375.30	0.96% ▲
RUB	37.37	2.02% ▲
KRW	2.53	1.61% ▲
JPY	27.27	0.63% ▲
CAD	2,173.20	0.61% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,902.05	0.15% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	24.61	1.86% ▲
Зэс	USD/lb.	312.90	2.00% ▲
Нүүрс	USD/MT	58.52	1.54% ▲
WTI газрын тос	USD/bbl.	39.85	-2.52% ▼
Brent газрын тос	USD/bbl.	41.77	-2.70% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.IX	1.70%
Бодлогын хүү	2020.IX	8.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.IX	8.22%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.IX	10.75%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.IX	3.76%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.IX	16.91%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.IX	10.46%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 46 компанийн 848.1 сая төгрөгийн 6,559,937 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Бэрх уул” /MSE: BEU/ компанийн хувьцаа 62.97%-аар буюу хамгийн ихээр өсөж 611.16 төгрөг хүрч хаагдсан бол “МИК холдинг” /MSE: MIK/ компанийн хувьцаа 13.99%-аар буурч 11,000.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Компанийн бондын хоёрдогч зах зээл дээр “Лэндмн ББСБ” ХК-ийн 6.0 сая төгрөгийн 60 ширхэг үнэт цаас арилжаалагдав.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

10-р сарын 23-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,565.2 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 индекс 17,396.36 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.60% -аар буурсан байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

### Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	LNBO-BD-19/06/21-C0008-17	60	6,000,070	100,000	100,010	52	17%

### Зах зээлийн тойм

Арилжигдсан үнийн дүн	Дүн (сая.төг)
Арилжигдсан үнийн дүн	854.1
Зах зээлийн үнэлгээ	2,565,227.0

### Зах зээлийн индексүүд

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	17,396.36	-0.60% ▼
MSE I индекс	7,968.69	-3.26% ▼
MSE II индекс	7,443.69	0.24% ▲

### Идэвхтэй арилжагдсан хувьцаа

Хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Бодь даатгал	5,843,036	660,130,959.2
МИК холдинг	5,064	55,704,000
Ард санхүүгийн нэгдэл	25,414	34,817,477
АПУ	42,487	24,226,781
Эрдэнэс сольюшинс	26,000	11,180,000

### Өсөлттэй хувьцаа

Хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Бэрх уул	611.16	62.97% ▲
Дархан хүнс	3,379.00	14.90% ▲
Монинжбар	91.00	13.75% ▲
Улаансан	830.00	12.95% ▲
Багануур	1,000.00	11.11% ▲

### Бууралттай хувьцаа

Хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
МИК холдинг	11,000.00	-13.99% ▼
Монгол шилтгээн	210.08	-6.63% ▼
Авто импекс	950.00	-5.94% ▼
Монгол базальт	181.10	-4.68% ▼
Эрдэнэ ресурс девелопмент корп	851.00	-4.18% ▼

### Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК

ҮЦК	Дүн (төг)
БиДиСек	1,465,199,067
Ард Секюритиз	64,110,519
Ти Ди Би Капитал	29,924,706
Бумбат-Алтай	26,016,158
Стандарт инвестмент	21,422,469

### Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	569.99	606,572.84
Таван толгой	5,765.00	303,614.88
МИК холдинг	11,000.00	227,802.52
Инвекор ББСБ	2,898.00	207,867.51
Говь	200.36	156,303.34

## НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.05.28-нд ОЛГОВ
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.29-нд ОЛГОВ
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-ны ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН ББСБ	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-нд ОЛГОВ
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.29-нд ОЛГОВ
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,404.8	1,000.0	29.4%	35.0	2020.04.07	2020.06.30-нд ОЛГОВ
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.30-нд ОЛГОВ
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-ны ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-ны ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.08.06-нд ОЛГОВ
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.07.09-нд ОЛГОВ
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.09.07-нд ОЛГОВ
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-ны ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.07.30-нд ОЛГОВ
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.04.16-нд ОЛГОВ
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.07.03-нд ОЛГОВ
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-ны ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.07.08-нд ОЛГОВ
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.04-нд ОЛГОВ
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.04.17-нд ОЛГОВ
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-ны ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.07.31-нд ОЛГОВ
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.29-нд ОЛГОВ
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-ны ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.07.21-нд ОЛГОВ
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
35	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	530.2	65.1	12.3%	6.3	2020.09.09	2020.09.28-нд ОЛГОВ

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### ОНЦЛОХ МЭДЭЭ

СЭХ-ны даргын 2020 оны 10-р сарын 22-ны өдрийн 1/4328 тоот албан бичгээр “Үндэсний хувьчлалын сан” ХХХОС-гийн нэгж эрхийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцсон бөгөөд нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжааг 2020 оны 10-р сарын 23-ны өдрөөс эхлүүлэх зөвшөөрлийг олгосон байна.

Нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжааг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дахь хөрөнгө оруулагчдын дансанд сангийн нэгж эрхийг байршуулан холбогдох мэдээллийг солилцсоны дараа буюу 2020 оны 10-р сарын 26-ны өдрөөс эхлүүлэхээр боллоо. Иймээс хөрөнгө оруулагчид анхдагч зах зээлийн арилжаанаас үлдсэн мөнгийг үнэт цаасны компаниараа дамжуулан буцаан авах эрх үүсэж байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

### ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

#### Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон “Капитал маркет корпораци ҮЦК” ХХК-ийн харилцагчдыг шилжүүлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 10-р сарын 21-ний өдрийн 953 тоот тогтоолоор үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан “Капитал маркет корпораци ҮЦК” ХХК-ийн харилцагчдыг нэмэлт төлбөргүйгээр үнэт цаасны дансаа “Эс Жи Капитал ҮЦК” ХХК-д нээлгэж хөрөнгийн зах зээлийн харилцаанд саадгүй оролцох боломжоор хангахаар шийдвэрлэсэн байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

#### “Борнуур” /MSE: BOR/ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд.

“Борнуур” /MSE: BOR/ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 10-р сарын 16-ны өдрийн №20/1 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2020 оны 11-р сарын 25-ны өдрийн 11:00 цагт хуралдуулахаар болсон байна.

Хурлын тов: 2020 оны 11-р сарын 16-ны өдрийн 11:00 цагт

Хуралдах газар: Төв аймгийн “Борнуур” сумын Соёлын төв

Бүртгэлийн өдөр: 2020 оны 11-р сарын 9-ний өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

- Компанийн санхүүгийн болон Үйл ажиллагааны тайлан
- Ноогдол ашиг тараахгүй байх ТУЗ-ийн шийдвэр
- 2020 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж, батлах
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийг сонгох

Хуралтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг ажлын өдрүүдэд 9:00-18:00 цагийн хооронд компанийн байранд болон өөрийн харилцагч брокер, дилерийн компаниар дамжуулан авч болно.

Холбоо барих утас: 88222323, 89114474

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

#### “Тандэм инвэст ББСБ” /MSE: VIK/ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд.

“Тандэм инвэст ББСБ” /MSE: VIK/ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 10-р сарын 13-ны өдрийн №5 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2020 оны 11-р сарын 25-ны өдрийн 09:00 цагт хуралдуулахаар болсон байна.

Хурлын тов: 2020 оны 11-р сарын 25-ны өдрийн 09:00 цагт

Хуралдах газар: Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона төв 11 тоот

Бүртгэлийн өдөр: 2020 оны 11-р сарын 2-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

- Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах;
- Хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;

Хуралтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг ажлын өдрүүдэд 9:00-18:00 цагийн хооронд компанийн байранд болон дараах холбоосоор авна уу.

Холбоо барих утас: 94002977, 99074804

Цахим шуудан: info@vik.mn

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

#### “Инвескор ББСБ” /MSE: INV/ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд.

“Инвескор ББСБ” /MSE: INV/ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 8-р сарын 26-ны өдрийн хурлын А/22-Т тоот тогтоолоор дагуу Компанийн 90%-ийн хөрөнгө оруулалттай бөгөөд Банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны чиглэлээс өөр чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Инвескор Эй Ай Лаб” ХХК болон Компанийн 99.84%-ийн Хөрөнгө оруулалттай “Инвескор Жапан” ХХК-ийн хувьцааг толгой компани болох “Эй Ай Би Жэй Капитал” ХХК-руу шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

## ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

### ОНЦЛОХ МЭДЭЭ

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 2020 оны 10-р сарын 23-ны өдөр зохион байгуулагдсан чуулганаар Монгол Улсыг ФАТФ-ын саарал жагсаалт буюу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гаргах талаар хэлэлцлээ. Уг чуулганд 130 гаруй улс орон болон олон улсын байгууллагын төлөөлөгчид оролцож, ФАТФ-ын Ерөнхийлөгч Доктор Маркус Плейер удирдаж явуулав. Монгол Улсыг ФАТФ-ын саарал жагсаалтаас гаргах асуудлыг хуралд оролцсон төлөөлөгчид санал нэгтгэйгээр дэмжлээ. Мөн Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ч чиглэлээр томоохон ахиц дэвшил гаргасанд явдалд баяр хүргэж, КОВИД-19 цар тахлын хүнд хэцүү үед газар дээрх хяналт шалгалтыг амжилттай зохион байгуулсан нь олон улсын сайн туршлага болсныг онцлон тэмдэглэв.

ФАТФ-ын Ерөнхийлөгч Доктор Маркус Плейер чуулганы дараа цахим хэвлэлийн бага хурал хийж, Монгол Улс үйл ажиллагааны төлөвлөгөөгөө амжилттай хэрэгжүүлснээр ФАТФ-ын хяналтаас буюу саарал жагсаалтаас гарсныг албан ёсоор мэдэгдэв.

Эх сурвалж: Монголбанк

### МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2020 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 7.3 их наяд төгрөг, үүнээс нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж нь 6.7 их наяд төгрөг байна. Нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж нь нийт орлогын 91.6%-ийг эзэлж байна.

Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 9.4 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2.7 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн хэмжээ 2020 оны 9-р сард 1.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 202.9 (25.4%) тэрбум төгрөг, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 1.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 94.7 (9.6%) тэрбум төгрөгөөр өсжээ. Харин улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 82.7 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 108.2 (56.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 83.3%-ийг татварын орлого, 8.3%-ийг татварын бус орлого, 8.0%-ийг ирээдүйн өв сангийн орлого, 0.4%-ийг тогтворжуулалтын сангийн орлого тус тус эзэлж байна.

Татварын нийт орлого 2020 оны эхний 9 сард 6.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.9 (13.1%) их наяд төгрөгөөр буурахад орлогын албан татвар 330.9 (18.5%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 183.9 (13.0%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 149.4 (22.0%) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 146.9 (8.3%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 74.7 (11.4%) тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 33.4 (5.7%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

### ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

БНХАУ-ын коксжих нүүрс болон гангийн үйлдвэрүүд нүүрсний нөөц бүрдүүлж, эрэлтийг өдөөж эхэллээ. Улмаар Монголоос нийлүүлж буй коксжих нүүрсний үнэ энэ долоо хоногийн эхээр тонн тутамдаа 20 юаниар өссөн, цаашид ч өсөх төлөвтэй байгааг "SXCoal" мэдээлж байна.

Тухайлбал: Гашуунсухайт-Ганцмод боомтоор тээвэрлэж буй түүхий нүүрсний татвар шингэсэн үнэ 810-840 юань орчим болж, 20 юаниар өсжээ. Харин өнгөрсөн долоо хоногийн эцсээр 1020-1040 юань байсан угаасан нүүрсний үнэ тонн нь 1030-1060 юань болсон байна. Австралид тавьсан хоригийн дараа БНХАУ-ын Хэбэй мужийн зарим үйлдвэрүүд Монголоос нүүрс худалдан авч эхэлсэн нь үнэд нөлөөлжээ.

БНХАУ-д нүүрсний эрэлт өндөр байгаатай холбоотойгоор БНХАУ-д тээвэрлэх эрхтэй Монголын нүүрсний тээврийн хэрэгсэл БНХАУ-д шууд нэвтрэх эрх олгохоор хоёр тал тохиролцсон байна. Энэ нь наймдугаар сард нээгдсэн "Ногоон гарц"-ын адил нүүрсний тээвэрлэлтийг эрс нэмэх төлөвтэй байгааг "SXCoal" онцолжээ.

10-р сарын эхний 20 хоногийн байдлаар Гашуунсухайт-Ганцмод боомтоор 1,055 нүүрсний автомашин нэвтрээд байгаа аж. Энэ нь өмнөх оны мөн үеэс 330 автомашинаар буюу 45.5%-аар өссөн үзүүлэлт юм.

Эх сурвалж: BloombergTV.mn

## ШИНЖЭЭЧИЙН БУЛАН

### ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ЗЭСИЙН ҮНЭ, ҮЙЛДВЭРЛЭЛ

Зэсийн үнэ 3-р сараас хойш 60 орчим хувиар өсөж, 2020 оны 10-р сарын 22-ны Пүрэв гарагийн арилжааны явцад Лондоны Металлын биржид тонн нь 7000 ам.доллар хүрснээр фьючерс үнэ сүүлийн хоёр жилийн дээд түвшинд хүржээ.

“International Copper Study Group”-аас 2020 оны 10-р сарын 23-ны өдөр 2020 оны эхний 7 сарын зэсийн зах зээлийн урьдчилсан үзүүлэлтүүдийг нийтэлсэн байна.

#### Зэсийн олборлолт 2020 оны эхний 7 сарын байдлаар.

- 2020 оны эхний 7 сард дэлхийн зэсийн үйлдвэрлэл 0.8%-аар буурсан байна. Коронавирусын цар тахалтай холбоотой хөл хорионы арга хэмжээ 4, 5-р сард зэсийн уурхайнууд олборлолтоо бууруулах, зогсоох арга хэмжээ авахад хүргэсэнтэй тул тус саруудад дэлхийн зэсийн олборлолт 4%-аар буурсан байна. Гэхдээ 5-р сараас эхлэн хөл хорионы арга хэмжээнүүд цуцлагдаж эхэлсэн болон зэсийн уурхайнууд ажилчдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээнүүд хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой зэсийн олборлолт эргэн сэргэж эхэлсэн байна.
- Перу улсад COVID-19, үйл ажиллагааны асуудлууд, цаг уурыг тааламжгүй байдал томоохон ордуудын олборлолтод нөлөөлсөнтэй холбоотой 2020 оны эхний 7 сард тус улсын зэсийн олборлолт 18%-аар буурсан ба 2020 оны 4, 5-р сард зэсийн олборлолт 2019 оны мөн үетэй харьцуулахад 38%-аар буурсан байна.
- COVID-19-тэй холбоотой хязгаарлалтууд болон үйл ажиллагааны бусад асуудлууд нь Австрали, Мексик, АНУ гэх мэт бусад томоохон зэс олборлогч орнуудын олборлолт буурахад нөлөөлсөн мөн нөлөөлсөн байна.
- Харин дэлхийн хамгийн том зэс олборлогч улс болох Чили улсад зэсийн олборлолт 2020 оны эхний 7 сарын байдлаар 1.5%-аар өссөн байна.

#### Зэсийн зах зээлд гарсан өөрчлөлтүүд.

Чили улсын Төрийн өмчит “Codelco” компани цар тахлын үед ажлын байраа цомхотгохоо мэдэгдсэнээр ажилчид энэ долоо хоногт ажил хаялт зарлаад байна. Мөн Канадын “Lundin Mining” компани Чили дэх “Candelaria” зэсийн уурхайн үйл ажиллагааг зогсоохоор боллоо. “Mina” хэмээх Үйлдвэрчний эвлэл 10-р сарын 8-ны өдрөөс хойш ажил хаялт зарлаад байгаа ажээ. Үүний зэрэгцээ уурхайн 550 орчим ажилчныг нэгтгэсэн “AOS” Үйлдвэрчний эвлэлтэй хэлэлцээрт хүрч чадаагүйн улмаас ийм шийдвэрт хүрчээ. Улмаар 2020 оны олборлолт, зардал, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөө эргэн харахаа мэдэгдсэн байна. Энэхүү уурхай энэ онд 160-175 мянган тонн зэс, 90-100 мянган тонн алт олборлох төлөвлөгөөтэй байжээ.

Мөн “International Copper Study Group” зэсийн эрэлт энэ онд нийлүүлэлтээс давах төлөвтэй байгааг мэдээллээ. Тус компани энэ онд 280 мянган тонн зэсийн илүүдэл үүснэ гэж тооцоолж байсан бол 52 мянган тонны хомсдол үүснэ гэж төсөөллөө өөрчилсөн байна.

Цар тахлын үед зэсийн гарц буурч, БНХАУ импортоо нэмэгдүүлсэн нь үүнд голлон нөлөөлнө гэж тайлбарлаж байна. Оны эхний есөн сард БНХАУ нийт 3.55 сая тонн боловсруулсан зэс импортлоод байгаа ба энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16%-аар өссөн дүн юм. Хэдий тийм боловч зэсийн бодит хэрэглээ нь ийм хэмжээгээр нэмэгдээгүй болохыг шинжээчид онцолж байна. “JP Morgan” гэхэд бодит хэрэглээг 0.5 %-аар өссөн гэж тооцоолж буй юм. Нийлүүлэлттэй холбоотой эрсдэлүүдээс үүдэн компаниуд зэсийн нөөцөө ихээр хуримтлуулж эхэлж байгаа ба энэ нь цаашдаа үнэд нөлөөлж магадгүй байна.

#### МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.